



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Жаргалант сумын 3 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/123/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас:70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Аудитор: С.Оюунжаргал
Утас: 99911390
цахим хаяг: Oyunjargals@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН ГУРАВДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.ГАНТОГОО ТАНАА

2023.02.16 № 02/НЧ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Жаргалант сумын Гуравдугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Жаргалант сумын Гуравдугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр гэрээний дагуу 2 ширхэг толгой компьютерыг цахим дэлгүүрээс ерөнхий гэрээний дагуу худалдан авалт хийсэн боловч хөрөнгө ирээгүй авлагаар бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант хугацаанд Боловсрол шинжлэх ухааны газраас 21.2 сая төгрөгийг сурах бичиг, морин хуур, түрээсийн сурах бичиг, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 6.1 сая, Хүүхэд бүрийг тэгш хамруулах төслөөс 3.5 сая төгрөгийн ном сурагч ширээ багц зөөврийн микрофон өсгөгч, Хүүхдийг ивээх сангаас 4.8 сая төгрөгийн проектор, зөөврийн компьютер гэх мэт үнэ төлбөргүйгээр, 59.8 сая төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус сургууль нь 960 хүүхэд хүлээн авах хүчин чадалтайгаас 2022 онд 38 бүлэгт 1095 хүүхэдтэйгээр 59 багштай, 83 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. 2022 онд 4 зорилт 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, биелэлтийг тооцон Жаргалант сумын Засаг даргад хүргүүлжээ

Тус сургууль нь 2022 онд 1-5 дугаар ангийн 21 бүлэгт нийт 85000 хүүхэд өдөр үдийн хоол арга хэмжээг хэрэгжүүлж 127.5 сая төгрөгийг зарцуулжээ.

021020300

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>130,138,880.43</u>	<u>148,653,556.41</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.0	12,290,797.88
312	Банканд байгаа бэлэн мөнгө	00.0	12,290,797.88
3121	Төгрөг	00.0	12,290,797.88
31211	Төрийн сангийн харилцах	00.0	12,290,797.88
33	АВЛАГА	5,047,000.00	00.0
335	Бусад авлага	5,047,000.00	00.0
3351	Байгууллагаас авах авлага	5,047,000.00	00.0
34	УРЬДЧИЛГАА	00.0	7,979,800.00
34600	Урьдчилж гарсан зардал	00.0	7,979,800.00
35	БАРАА МАТЕРИАЛ	125,091,880.43	128,382,958.53
35300	Бэлэн бүтээгдэхүүн	3,033,970.00	3,033,970.00
354	Хангамжийн материал	122,057,910.43	125,348,988.53
35420	Аж ахуйн материал	457,800.00	457,800.00
35470	Бусад хангамжийн материал	121,600,110.43	124,891,188.53
36	НӨӨЦИЙН БАРАА	00.0	00.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,387,030,592.38</u>	<u>1,358,357,585.45</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,387,030,592.38	1,358,357,585.45
392	Биет хөрөнгө	981,268,342.50	952,675,335.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,103,915,898.20	1,103,915,898.20
39202	Хуримтлагдсан элэгдэл	(261,146,128.80)	(349,121,642.28)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	310,073,362.40	379,552,376.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(276,690,079.24)	(298,736,831.31)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	178,953,867.00	199,556,654.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(124,967,358.82)	(137,466,779.14)
39214	Бусад үндсэн хөрөнгө	37,631,712.76	37,631,712.76
39215	Хуримтлагдсан элэгдэл	(25,251,445.78)	(28,402,012.66)
39217	Ном	38,748,514.78	45,745,959.10
393	Биет бус хөрөнгө	405,762,249.88	405,682,249.88
39301	Программ хангамж	857,000.00	857,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(742,750.12)	(822,750.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	405,648,000.00	405,648,000.00
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	00.0	00.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,517,169,472.81</u>	<u>1,507,011,141.86</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.0	00.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,517,169,472.81</u>	<u>1,507,011,141.86</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,517,169,472.81	1,507,011,141.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,089,808,461.00	1,089,808,461.00
51101	Өмч: - төрийн	1,089,808,461.00	1,089,808,461.00
512	Хуримтлагдсан үр дүн	(459,846,161.91)	(470,004,492.86)
51210	Өмнөх үеийн үр дүн	(459,846,161.91)	(460,238,335.21)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(9,766,157.65)

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	887,207,173.72	887,207,173.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,517,169,472.81	1,507,011,141.86

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,608,534,496.63	2,073,764,683.92
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,185,763.63	51,932,283.92
120	Нийтлэг татварын бус орлого	11,615,363.63	51,932,283.02
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,615,363.63	48,589,683.92
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,550,000.00	1,675,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,065,363.63	46,914,683.92
120009	Бусад орлого	0.00	3,342,600.00
121	Хөрөнгийн орлого	0.00	0.00
122	Тусламжийн орлого	570,400.00	0.00
122001	Хандив тусламж /дотоод/	570,400.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,596,348,733.00	2,021,832,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,305,503,800.00	1,680,389,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	1,680,389,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,305,503,800.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,166,133.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,166,133.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	258,678,800.00	341,442,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	258,678,800.00	341,442,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,725,425,161.47	2,083,530,841.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,725,425,161.47	2,083,530,841.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,665,420,882.98	1,980,877,712.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,104,434,339.00	1,298,890,491.00
210101	Үндсэн цалин	717,314,400.00	1,147,962,381.00
210102	Нэмэгдэл	328,373,339.00	104,679,075.00
210104	Урамшуулал	58,746,600.00	46,249,035.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	142,684,212.06	160,740,337.22
210201	Тэтгэврийн даатгал	98,734,412.06	110,718,031.86
210202	Тэтгэмжийн даатгал	10,987,400.00	13,027,344.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,789,900.00	10,408,435.94
210204	Ажилгүйдлийн даатгал	2,197,500.00	2,415,548.76
210205	Эрүүл мэндийн даатгал	21,975,000.00	24,170,975.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	262,696,398.00	297,831,871.11
210301	Гэрэл, цахилгаан	4,300,300.00	9,912,645.11
210302	Түлш, халаалт	231,932,498.00	254,177,626.00
210303	Цэвэр, бохир ус	26,463,600.00	33,741,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,712,865.00	100,000.00
210401	Бичиг хэрэг	1,360,965.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,150,000.00	0.00
2105	Норматив зардал	6,437,872.00	24,027,000.00

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,078,572.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,612,900.00	0.00
210604	Урсгал засвар	2,612,900.00	1,112,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,881,000.00	15,846,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,873,000.00	3,342,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	12,504,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	135,961,296.92	182,328,412.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,514,502.00	33,953,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,278,200.00	22,622,710.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	129,168,594.92	125,752,252.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,004,278.49	102,653,129.49
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	59,601,368.00	100,452,778.20
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	41,287,500.00	100,452,778.20
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	18,313,868.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	402,910.49	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	402,910.49	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	2,200,351.29
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	2,200,351.29
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(116,890,664.84)	(9,766,157.65)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	697,706.00	0.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	697,706.00	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(697,706.00)	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(117,588,370.84)	(9,766,157.65)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,597,898,733.00	2,025,175,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,550,000.00	3,342,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,550,000.00	3,342,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,550,000.00	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,550,000.00	0.00
120009	Бусад орлого	0.00	3,342,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,596,348,733.00	2,021,832,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,305,503,800.00	1,680,389,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	1,680,389,800.00

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,305,503,800.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,166,133.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,166,133.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	258,678,800.00	341,442,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	258,678,800.00	341,442,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,597,898,733.00	2,014,559,202.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,597,898,733.00	2,014,559,202.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,537,394,454.51	1,884,776,350.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,098,746,800.00	1,296,538,865.52
210101	Үндсэн цалин	717,114,400.00	901,233,907.44
210102	Нэмэгдэл	322,885,800.00	330,543,421.08
210104	Урамшуулал	58,746,600.00	64,761,537.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	148,330,700.00	162,207,100.00
210201	Тэтгэврийн даатгал	104,380,900.00	104,682,457.19
210202	Тэтгэмжийн даатгал	10,987,400.00	18,518,842.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,789,900.00	10,457,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,197,500.00	2,595,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,975,000.00	25,953,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	257,565,900.00	294,729,148.71
210301	Гэрэл, цахилгаан	3,855,300.00	6,809,922.71
210302	Түлш, халаалт	227,247,000.00	254,177,626.00
210303	Цэвэр, бохир ус	26,463,600.00	33,741,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,767,865.00	0.00
210401	Бичиг хэрэг	1,410,965.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	975,000.00	0.00
210404	Ном, хэвлэл	80,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргчдийн устгал, ариутгал	1,353,600.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	948,300.00	0.00
2105	Нормативт зардал	1,946,800.00	0.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	587,500.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,359,300.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,612,900.00	1,692,900.00
210604	Урсгал засвар	2,612,900.00	1,692,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,608,000.00	15,846,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,600,000.00	3,342,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	12,504,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,815,489.51	113,761,636.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,150,000.00	94,993,536.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,665,489.51	18,768,100.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,504,278.49	129,782,851.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,101,368.00	127,582,500.60
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	41,787,500.00	127,582,500.60
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	18,313,868.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	402,910.49	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	402,910.49	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	2,200,351.29
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	2,200,351.29
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	<u>10,615,797.88</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	10,615,797.88
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	12,290,797.88

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,089,808,461.00	887,253,058.72	(342,303,676.07)	1,634,757,843.65
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	45,885.00	45,885.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,089,808,461.00	887,253,058.72	(342,257,791.07)	1,634,803,728.65
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	(45,885.00)	0.00	(45,885.00)
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(117,588,370.84)	(117,588,370.84)
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,089,808,461.00	887,207,173.72	(459,846,161.91)	1,517,169,472.81
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,089,808,461.00	887,207,173.72	(459,846,161.91)	1,517,169,472.81
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(392,173.30)	(392,173.30)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,089,808,461.00	887,207,173.72	(460,238,335.21)	1,516,777,299.51
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(9,766,157.65)	(9,766,157.65)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,089,808,461.00	887,207,173.72	(470,004,492.86)	1,507,011,141.86

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,026,850,000.00	2,012,358,850.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,026,850,000.00	2,012,358,850.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,892,998,200.00	1,884,776,350.23
2101 81834	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,297,656,200.00	1,296,538,865.52
210101	Үндсэн цалин	903,010,000.00	808,608,844.33
210102	Нэмэгдэл	269,009,400.00	321,838,321.08
210101	Үндсэн цалин	34,076,600.00	34,076,600.00
210102	Нэмэгдэл	3,985,800.00	3,985,800.00
210101	Үндсэн цалин	58,991,200.00	58,548,463.11
210102	Нэмэгдэл	4,719,300.00	4,719,300.00
210104	Урамшуулал	6,625,900.00	6,625,900.00
210104	Урамшуулал	17,238,000.00	58,135,637.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	162,207,100.00	162,207,100.00
210201	Тэтгэврийн даатгал	110,300,800.00	104,682,457.19
210202	Тэтгэмжийн даатгал	12,900,500.00	18,518,842.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,457,400.00	10,457,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,595,400.00	2,595,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	25,953,000.00	25,953,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	296,875,200.00	294,729,148.71
210301	Гэрэл, цахилгаан	8,951,000.00	6,809,922.71
210302	Түлш, халаалт	254,182,600.00	254,177,626.00
210303	Цэвэр, бохир ус	33,741,600.00	33,741,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,747,200.00	1,692,900.00
210604	Урсгал засвар	1,747,200.00	1,692,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,854,700.00	15,846,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,342,600.00	3,342,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,512,100.00	12,504,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	118,657,800.00	113,761,636.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	99,889,700.00	94,993,536.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,768,100.00	18,768,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	133,851,800.00	127,582,500.60
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	133,851,800.00	127,582,500.60
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	133,851,800.00	127,582,500.60
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,026,850,000.00	2,024,649,648.70
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,685,407,400.00	1,685,407,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,685,407,400.00	1,685,407,400.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	341,442,600.00	341,442,600.00

132001	Орон нутгийн төсвөөс	341,442,600.00	341,442,600.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	12,290,797.88
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	83.00	83.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	55.00	55.00
620003	Үйлчлэх ажилтан	27.00	27.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	992.00	992.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	992.00	992.00
630001	Төрийн өмчит ЕБС	992.00	992.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	-3,342,000.00	-3,342,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	3,342,000.00	-3,342,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	3,342,000.00	-3,342,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	3,342,000.00	-3,342,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		3,342,000.00	-3,342,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	3,342,000.00	-3,342,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	3,342,000.00	-3,342,000.00
131101	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,342,000.00	-3,342,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ховд аймгийн Жаргалант сумын гуравдугаар сургууль нь 2022 оны хичээлийн жилийг “Эрүүл бие бялдартай, зөв хандлагатай, мэдлэгээ хэрэглээ болгодог, бүтээлч хүүхэдтэй болно” гэсэн зорилго дэвшүүлэн ажиллаж байна. Энэхүү зорилгынхоо хүрээнд “Эрүүл бие бялдартай хүүхдийг төлөвшүүлж эрүүл зөв дадлыг хэвшүүлнэ”, “Зөв эерэг хандлагатай хүүхдийг төлөвшүүлнэ”, “Мэдлэгээ хэрэглээ болгоход анхаарч бүтээлч хүүхдийг төлөвшүүлнэ” гэсэн тэргүүлэх зорилт тавин ажиллажээ.

Гуравдугаар сургууль нь 4 заах аргын нэгдэлд сургалт бусад үйл ажиллагаа явуулдаг ба байгалийн ухааны заах аргын нэгдэлд-21, нийгмийн ухааны заах аргын нэгдэлд -16, бага ангийн заах аргын нэгдэлд-21, захиргаа аж ахуйн заах аргын нэгдэлд-24, нийт 83 багш ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус сургууль нь бага ангийн-21, дунд, ахлах ангийн-37 багштай. Зөвлөх 2, тэргүүлэх 28, заах аргач 13, зэрэггүй 13 нийт багш нарын 74.% нь мэргэжлийн зэрэгтэй, 44 багш бакалавр, 12 багш магистр зэрэгтэй байна. Нийт багш нар 100% багшлах эрхтэй.

2022 онд хийсэн багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр I түвшний багш-0, II түвшний багш -3, III түвшний багш -5, бусад багш нар IV 11түвшинд шалгагдсан ба нийт оноогоор 32.6% авч аймгийн дунджаас 3.7%, улсын дунджаас 1.1% ахисан амжилтыг үзүүлээ.

Жаргалант сумын Гуравдугаар сургуульд 2022-2023 оны хичээлийн жилд 1 дүгээр ангид 131 сурагч элсэж, 21 бүлэгт 6002 сурагч суралцаж, анги дүүргэлтийн дундаж 28.6 ба бага анги буюу 1-5 дугаар ангийн 21 бүлэгт 625, дунд анги буюу 6-9 дүгээр ангийн 12 бүлэгт 340, ахлах анги буюу 10-12 дугаар ангийн 6 бүлэгт 147 сурагч суралцаж байна. Нийт шилжиж ирсэн 45, шилжиж явсан 50 сурагч байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Боловсролын тухай, Бага дунд боловсролын тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд 2022 онд нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. 2022 онд Боловсролын тухай хуульд 3 удаа, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд 2 удаагийн өөрчлөлт оржээ.

Боловсролын байгууллагын багш ажилтанд үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл олгох журмуудад өөрчлөлт орсон байна. 2022 онд боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах, багшийн хөгжлийг дэмжих, цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх, багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах журмыг шинээр баталжээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.

2022 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар 22-ны өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу Жаргалант сумын Гуравдугаар сургуулийн даргын 2022 оны 06 дугаар сарын 10-ны А/41 дүгээр тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогыг зохион байгуулж хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдалд хяналт тавих ажлуудыг зохион байгуулсан байна.

Байгууллагын даргын 2022 оны 01 дүгээр сарын 06-ний өдрийн А/07 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй комисс байгуулагдаж байгууллагын гадаад, дотоод орчинд тавигдах шаардлагын хүрээнд хүрээнд 23 шалгуур үзүүлэлтийг тавьж үнэлгээ хийхэд 70,8 хувьтай үнэлэгдсэн байна. Сургуулийн эзэмшил газрын талбайн өндрөөс биет унах эрсдэлтэй хэсэгт хамгаалалтын бүс тогтоож анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулаагүй, анги танхимын агаар сэлгэлтийн хоолой төхөөрөмжид шинэчлэл үйлчилгээ хийгдээгүй, сангийн урсгал засвар хийгдээгүйн хүүхэд сурах орчинд сөрөг нөлөө үзүүлсэн гэм мэт шалтгаан нөлөөлсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын Гуравдугаар сургууль нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жаргалант сумын Гуравдугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10.2 сая төгрөгөөр буюу 1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	12,290.8	12,290.8
Авлага	5,047.0		(5,047.0)
Урьдчилж гарсан зардал		7,979.8	7,979.8
Бараа материал	125,091.8	128,383.0	3,291.1
Үндсэн хөрөнгө	1,387,030.5	1,358,357.6	(28,672.9)
Нийт хөрөнгө	1,517,169.3	1,507,011.1	(10,158.2)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,089,808.5	1,089,808.5	-
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,517,169.3	1,507,011.1	(10,158.2)

Дээрх хүснэгтээс харахад Ховд аймгийн Жаргалант сумын Гуравдугаар сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10.2 мянган төгрөгөөр өссөний материаллаг нөлөө нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн

хөрөнгийн данстай холбоотой бөгөөд балансын үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25 өдрийн 18 дугаартай албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 12.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- ✓ Ай ти зон ХХК-иас 2 ширхэг толгой компьютер худалдан авахаар гэрээ байгуулж санхүүжилт олгосон ч тайлант хугацаанд ирээгүй урьдчилж гарсан зардал дансанд 7.9 сая төгрөгөөр өссөн
- ✓ Байгууллагын хөрөнгөөр 59.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 37.1 сая төгрөгийн хандиваар хөрөнгө авч тайланд хугацаанд 125.7 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл байгуулсантай холбоотой 28.6 сая төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1685.3 сая, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 0.6 сая, орон нутгийн төсвөөс 341.4 сая нийт зарлагыг 2,027.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн батлагдсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс 1683.6 сая, орон нутгийн төсвөөс 341.4, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1.7 сая төгрөг нийт 2026.7 сая төгрөг гүйцэтгэлээр санхүүжиж 2,014 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж 14.4 сая төгрөгийн төсвийг хэмнэж орон нутгийн төсөвт 2.2 сая төгрөгийг төвлөрүүлж, гүйцэтгэлээр санхүүжиж байгаатай холбоотой 12.29 сая төгрөгийн дансны үлдэгдэлтэй байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2012.4 сая төгрөг 98 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71802/80226-тогтмол зардал	5,000.5	5,000.5	-	100%
2	71802/80312-сургалт семинар	2,502.4	2,456.4	46.0	98%
3	70802/81801 -үдийн цай	133,851.8	127,582.5	6,269.30	95%
4	70802/81605-Эрүүл мэнд	5,755.6	5,755.6	-	100%
5	71802/81816-Нөхөн хангалт	67,435.0	62,689.8	4,745.2	93%
6	71802/81823-Боловсролын байгууллагын багш	11,260.9	11,260.9	-	100%
7	71802/81834-Үндсэн цалин	1,375,450.8	1,374,768.2	682.6	100%
8	71802/81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	79,128.5	78,685.8	442.7	99%

9	71802/81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	1,675.0	1,570.0	105.0	94%
10	71802/81848 сурах бичгийн түрээс	3,342.6	3,342.6	-	100%
11	71802/80111-тогтмол зардал	298,622.4	296,422.0	2,200.4	99%
12	71802/80112-нийтлэг үйлчилгээ	42,820.2	42,820.2	-	100%
ДҮН		2,026,845.7	2,012,354.5	14,491.2	98%

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар түрээсийн номын төлбөр 3.3 сая төгрөг орж ирснийг үндсэн данс руу шилжүүлж зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Жаргалант сумын Гуравдугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор С.Оюунжаргал 2023 оны 02 дугаар сарын 10-ний өдрөөс 02 дүгээр сарын 16-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,081.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 31.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 24.9 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын хэмнэгдсэн төсвөөс гүйцэтгэлийн үнэлгээгээр улсын дунджаас доогуур үнэлэгдсэн байгууллагын менежер, нийгмийн ажилтан, сэтгэлзүй нарт 2.2 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон зөрчил илэрлээ.

12 дугаар зүйлд заасан бусад хангамжтай холбоотой гар утасны зардалд 1.9 сая төгрөгийн зардал гарсан ба энэ нь 48 багш нарын дата хэрэглээнд Боловсрол шинжлэх ухааны сайдын баталсан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах журмын дагуу зарцуулагдсан байна.

14 дүгээр зүйлд заасан цахим худалдан авалтын хүрээнд 67.4 сая төгрөгийн таблет, зөөврийн компьютер, толгой компьютерын худалдан авалт хийсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд таван сая төгрөгөөс дээш орлогын гүйлгээ, төсөв хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэр, тендер худалдан авалтын мэдээллийг мэдээлээгүй, байсныг аудитын явцад залруулан мэдээлүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээн0ий үр дүн

Өмнөх аудитаар Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсөвт зардлын 10 хувиас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй, төсөвт төвлөрүүлээгүйтэй холбоотой 139.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	139.0	1	139.0	100.0
Нийт дүн	1	139.0	1	139.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах эрсдэлтэй асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7.8 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 7.8 сая төгрөгийн алдааг залруулав.

Үүнд: Мөнгөн гүйлгээний тайланд орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн 2.2 сая төгрөгийг, орлого талд бууруулан бичилт хийснийг, урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг дансанд, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээ, төсвийн хөрөнгө зарцуулахтай холбоотой гарсан шийдвэр, тендер худалдан авалтын мэдээлэл, анхан шатны баримтгүй арга хэмжээнд хөрөнгө зарцуулсныг нөхөн баримт бүрдүүлүүлж аудитын явцад тус тус залрууллаа.

Аудитаар нийт 1140.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 1140.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Зөвлөмж

Илрүүлэлт: Байгууллагын спорт заалыг Шинэ дулааны станцад түрээсэлсэн төлбөр жилийн 600.0 мянган төгрөг, Хөдөлмөр халамж үйлчилгээний газруудад сарын 90.0 мянган төгрөгөөр гэрээ хийж түрээсэлсэн ч гэрээнд заасан хугацаанд түрээсийн төлбөр төвлөрүүлээгүй, хоолны газрын түрээсийн төлбөрийн 40 хувийг улсын төсөвт төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж Хичээлийн жилд багтаан гэрээний түрээсийн орлогыг бүрэн төвлөрүүлж ТӨБЗГ-ын тогтоолын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруула агүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Татан төвлөрүүлсэн хөрөнгийг орлого бууруулж бичилт хийсэн	1	2200.4			1	2200.4	1	2200.4				
Шилэн дансанд мэдээлэл байршуулаагүй	1		1	-			1	-				
Сургалт семинарын зардал, багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх арга хэмжээнд зарцуулсан	1	5594.8	1	5594.8			1	5594.8				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хөрөнгө анхан шатны баримтгүй												
Дүн	4	7795.2	1	5594.8	2	2200.4	3	7795.2	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын спорт заалыг түрээсэлсэн ч гэрээнд заасан хугацаанд түрээсийн төлбөр төвлөрүүлээгүй, өмчийн санд тушаагаагүй	1	1,140.0					1	1,140.0
Дүн	1	1,140.0	-	-	-	-	1	1,140.00

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

У.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:

С.ОЮУНЖАРГАЛ